

## Иргэдийн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлт

2016 оны хоёрдугаар улирлын байдлаар манай байгууллагын цахим системээр 8 хүсэлт бүртгэгдсэн. 8 хүсэлтэд хуулийн хугацаанд нь саналаа өгсөн байна.

Өргөдөл гомдлыг дараахь шат дамжлагаар шийдвэрлэж байна. Үүнд:

1. Цахим системээр ирсэн өргөдлийг хүлээн авч удирдлагад танилцуулна.
2. Удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтсийн даргад цахимаар шилжүүлнэ.
3. Хэлтсийн дарга нар холбогдох мэргэжилтэнд цохож шилжүүлнэ.
4. Мэргэжилтэн өргөдлийн хариуг удирдлагад танилцуулна.
5. Өргөдлийг тухайн эзэнд нь албан бичгээр, утсаар болон бусад байдлаар танилцуулна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн ажил:

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийж байна.
- Өргөдөл гомдлын хяналтын цонхыг мэргэжилтэн бүрийн компьютерт суулгасан.